

Петро Матад Лимитед
/ цаашид “Петро Матад” юмуу эсвэл “Компани” гэх/
Үйл ажиллагааны талаарх шинэ мэдээлэл

Петро Матадын ТУЗ нь тус компаний үйл ажиллагааны явцийн талаарх дараах мэдээлэл өгөхийг хүсч байна.

XX Блокын өрөмдлөгийн хөтөлбөр

Монгол улсын зүүн хэсэгт байрлах тус компаний XX блокын Давсан Толгойд хийж гүйцэтгэх 3 цооногийн 2009/2010 онуудын өрөмдлөгийн хөтөлбөр өвөл завсарлаад удахгүй дахин эхлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Петро Матадын бэлтгэл ажлын баг болон гэрээлэгчид 2010 оны 4 сарын 27-ноос эхлэн Давсан Толгойд очиж талбайн бэлтгэлийн ажлууд, хээрийн байрны засвар үйлчилгээ болон гурван цооногнуудын бэлтгэл ажилдаа орууд байгаа. Монгол улсад онцгой хүйтэн урт өвөл болсны дараа бэлтгэл засвар үйлчилгээний ажил тооцоолж байснаас илүү их байгаа боловч ажил урагштай явж аливаа саатал, урт хугацааны бэрхшээлгүйгээр бэлтгэл, засвар үйлчилгээний ажлыг хийж дуусгахаар тус Компани ажиллаж байна.

Петро Матадын өрөмдлөгийн гэрээлэгч Ансай Юүхуа Ойл Тех Компани одоогоор Хятадын өрмийн ажиллагсдын виза болон ажлын зөвшөөрлийг авах ажлыг дуусгаад энэ долоо хоногт талбай дээр хүрэлцэн ирэхээр болоод байгаа. Талбайд ирмэгцээ тэд өрмийн машины засвар үйлчилгээг хийж гүйцэтгээд энэ сарын сүүл гэхэд өрмийн ажлаа эхлэх болно.

Тус Компани өрмийн туршлагатай удирдлагын багийг хөлслөн авсан бөгөөд өрмийн мастер Ричард Коле гэдэгжээр удирдуулсан олон улсын болон Монгол улсын өрмийн мэргэжилтнүүд түүнд багтаж байгаа юм. Өрмийн багийн олон улсын гишүүд болох өрмийн ахлагч, цооногийн геологич / газрын тосны физикч болон талбайн үйлчилгээний менежер зэрэг хүмүүс нь Монгол улсад ижил төстэй төслүүд урьд өмнө хийж гүйцэтгэж байсан бөгөөд олон улсын арвин туршлагатай хүмүүс байгаа болно.

Өвлийн дараа ажилаа сэргээн эхлэх хуваарийн хувьд бол тус Компаний XX блокоос хойхон XIX блок дээр ажиллаж байгаа Петро Чайна Дасчин Тамсаг компанийнхтай ижилхэн хуваариар гүйцэтгэж байна.

Хайгуул

Петро Матад Компаний шинээр томилогдсон Хайгуулын Менежер Доктор Жэймс Күүган мөн шинээр томилогдсон ахлах геофизикч доктор Курт Констениус болон талбайн геологич Жастин Тулли нарын хамтаар 4 сарын 15-наас ажлаа эхээд байна. Уг хайгуулын баг нь урд нь байсан болон шинээр авсан Монголын мэргэжилтнүүдийн хамтаар тус Компаний хайгуулын хөтөлбөр дээр ажиллана.

Хайгуулын нэгжийн өгөгдлийн бааз, програм хангамж болон тоног төхөөрөмжүүдийг бий болгохын зэрэгцээгээр тэд тус Компаний эрдэм шинжилгээний хамтрагчидтай харилцаа тогтоон 2010 оны геофизикийн болон талбайн геологийн өтөлбөрүүдийг боловсруулна. Петро Матадын ХХ Блокын хайгуулын өргөн цар хүрээтэй өгөгдлийн сан дээр тэд нэмж импортлон оруулж ирж байгаа гэсэн үг юм.

Петро Матадын 2009 оны 2-р сар гэхэд цуглуулжүнэлгээ хийсэн нэмэлт мэдээллүүд дотор Монголын Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газраас /МГТХЭГ/ зарласан Петро Чайнагийн охин компани болох Петро Чайна Дачин Тамсаг компаний XIX блок дээр тогтоосон нөөц мөн багтаж байгаа болно. МГТХЭГ газрын хэвлийд ойролцоогоор 900 сая баррель газрын тос 2,5 сая куб метр байгалийн хий байгааг зарласан. Хэдийгээр тус Компани тухайн мэдээллийн талаарх техникийн нарийнүйлсэд нэвтрэх бололцоо маш бага байгаа хэдий ч уг мэдээлэл болон тус Компаний ХХ блокын боломжит эерэг аспектиуд байгаад маш тааламжтай хандаж байгаа билээ.

Дээр дурьдсан эрдэм шинжилгээний хамтран ажиллагсдын нэг нь Английн Лэйсистер Их Сургуулийн доктор У.Д.Каннингхам юм. Тэрээр асар их зохиол бүтээл тууриг авсан алдартай эрдэмтэн хүн бөгөөд Алтай болон Говь Алтайн бүсүүдэд 15 жил эрдэм шинжилгээний ажил идэвхтэй явуулсан үн. Тэр бүсүүдэд манай Компаний Бүтээгдхүүн Хуваах Гэрээнүүд бүхий IV ба V блокууд байрлаж байгаа юм. Хамтын ажиллагааны эхний үе шатанд тэдгээр блокуудын нарийвчилсан геологийн шинжилгээ хийж үүрс устөрөгчийн хэтийн төлөвтэй эсэхийг тодорхойлох явдал байсан юм.

Доктор Саннингхамын судалгаагаар IV ба V блокуудад наад зах нь 8 чухал нүүрсустөрөгчийн хэтийн төлөвтэй газрууд байгааг тодорхойлсон байгаа. Тэдгээрээс гурав нь хамгийн их хэтийн төлөвтэй байгаа бөгөөд шатдаг занар газрын гадаргууд ил гарч ирсэн жишээлбэл битумений орд бүхий сав газрын томоохон атираанууд байгаа нь тогтоогдсон. Эдгээр гурван атираанууд нь 300 квадрат км, 1000 кв. км болон 3100 кв.км талбайнуудыг хамран оршиж байгаа юм.

Эдгээр урьдчилсан үнэлгээнүүдийг ашиглан тус Компаний хайгуулын шинэ баг IV ба V блокуудад явуулах 2010 оны хайгуулын өтөлбөрөө төлөвлөж байгаа болно. Монголын геофизикийн гэрээлэгч Геосан ХХК үүрэхайгуулын өтөлбөрийн эхний хэсэг болох 4000 цэгийн *infil* буюу нягтралыг нэмэгдүүлэх зорилготой гравиметрийн зураглалын ажил явуулж эхлээд байна. Үүнийг дуусхаар Петро Матад компани уг судалгааг Монголын засгийн газрын холбогдох байгууллагуудаас авсан орчин үеийн грэйвити судалгааны өгөгдлийн сан дээр нэмэн судлах болно.

Компаний удирдлага, Нийгмийн Үйл ажиллагаа, Байгаль орчин, Хөдөлмөр хамгаалал, Аюулгүй ажиллагаа

2010 оны 1 сард ТУЗ Компаны Удирдлага, Нийгмийн Үйл Ажиллагааны болон Байгаль Орчны Хороо байгуулах шийдвэр гаргасан. Эцэслэн байгуулагдсаныхаа дараа уг Хороо нь компаний удирдлагын хамгийн сайн практикыг бий болгож нийгмийн үйл ажиллагаа болон байгаль орчны бодлогуудыг боловсруулан

хэрэгжүүлэх юм. Хэдийгээр Петро Матадад эдгээр чиглэлүүдээр өөрийн гэсэн зохих заавар журам, төлөвлөгөө, үйл ажиллагаа байгаа ч гэсэн бүхий л үндэсний болон олон улсын хууль ёсны шаардлагууд болон Европын Сэргээн Босголт ӨХЖлийн Банкны хөрөнгө оруулалт орж ирж байгаа зэрэгтэй уялдуулан тус компанид хамгийн сайн практик болон олон улсын холбогдох журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг болгох шаардлагатай байгаа болно.

Хамгийн сайн практикийн нэг хэсэг бол Сангийн Тайлагналтын Зөвлөлийн нийтэлсэн Компаний удирдлагын Нийтлэг Журмууд /"Нийтлэг Журам"/, Арилжаалагддаг Компаниудын Холбооноос нийтэлсэн Компаниудын Альтернатив Хөрөнгө Оруулалтын Зах Зээлийн Компаний Удирдлагын Зааврууд болон Олборлох Салбаруудын Ил Тод Байдлын Санаачлага байгууллагын Олон Улсын Секретариатын нийтэлсэн Олборлох Салбаруудын Ил Тод Байдлын Санаачлагууд зэрэгт заасан журмуудыг өөрийн байгууллагадаа авч хэрэгжүүлэх асуудал чухал байгаа юм.

Тус Компани нөхмөөрийн ХХ блокын өмнө хийлгэсэн Байгаль Орчны Нарийвчилсан Үнэлгээг шинэчлэн Монгол улсын холбогдох яамаар саяхан батлуулсан болно. Өмнөх ийг зөвхөн Монгол улсын хуультай л зохицуулж гаргасан БОНУ байсан бол шинэчлэгдсэн БОНУ нь Дэлхийн Банкны байгаал орчны нөлөөллийн үнэлгээний стандартуудад нийцүүлэхээр болж чадсан билээ.

Тус Компани нөхмНийгмийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөө өгөө эцэслэн боловсруулж байгаа бөгөөд засгийн газар болон орон нутгийн олон нийттэй ойр дотно харилцаагаа улам үр бэхжүүлэн албан ёсны болгож байгаа. Мөн тус Компаний бүхий л үйл ажиллагааны аспектиудын менежменттэй интеграцлагдсан, хууль журамд үрүн нийцсэн өдөлмөр х амгаалал, аюулий ажиллагааны менежментийн системийг боловсруулаад байна.

Тус компаний үйл ажиллагааны талаар тайлбарлахдаа Гүйцэтгэх захирал Дуглас МкГэй ингэж хэлсэн болно: "Гүүлийн 8 сарын хугацаанд Петро Матад компани нь өөрийн хайгуулын багийг өргөтгөх болон өрөмдлөгийн хяналтын дотоод багийг бий болгох зэргээр дотоод үжин чадлаа ихээхэн нэмэгдүүлсэн. Ингэснээр 2010 оны өрөмдлөгийн болон хайгуулын улирлыг үр ашигтай болгох боломжийг манай Компанид бий болгож байгаа юм. Давсан Толгойд тавих гурван цооногийн өрөмдлөгийн хөтөлбөрийн хувьд гэвэл Монгол улс энэ жил урт бөгөөд хүнд хэцүү өвлийг давж малын хорогдол, хүн ард болон эдийн засагт асар их хохирол амссан талаар цохон тэмдэглэмээр байна. Манай өрөмдлөгийн хөтөлбөрийн нэг шинэлэг шинж чанар нь бид зургаан Монгол өрөмдлөгийн дадлагжигчдыг авч ажиллуулж байгаа бөгөөд бусад өрөмдлөгийн хөтөлбөрүүдэд Монголын мэргэжилтнүүдийг авч ажиллуулж байгаа. Бид Монголын мэргэжилтнүүдэд газрын тосны салбарт ажиллах бололцоог нь аль болох өргөжүүлэх үүрэг хүлээн ажиллаж байгаа бөгөөд ажил дээрх сургалт зохион байгуулах болон сургасан хүмүү сээ манай компани үйл ажиллагаанд оролцох ажлын байраар хангах тал дээр идэвхтэй ажиллаж байгаа болно.

IV ба V блокуудын талаарх ширээн дээр хийгдэж байгаа геологийн судалгаануудын үр дүнгүүд их нааштай байгаа бөгөөд бид эдгээр талбайнууд дахь хайгуулын ажиллагааг ихээхэн хэмжээгээр түргэтгэнэ гэж үзэж байгаа. Зайлшгүй шаардлагатай

учраас шинээр авч ажиллуулж байгаа геологийн багийн шинэ гишүүд маань өмнөх байсан Монгол ажиллагсад дээр нэмэгдснээр бид эдгээр анхдагч судалгаануудаа амжилттай явуулж энэ хайгуулын улирлыг үр өгөөжтэй өнгөрүүлэх байх гэж найдаж байна”.

Энэхүү мэдээний техникийн мэдээллийг тус Компаний Хайгуулын Менежер доктор Жэймс Күүган хянаж үзсэн болно. Доктор Күүган Хойд Америк болон олон улсын хайгуул, боловсруулалтын ажлын 29 жилийн туршлагатай газрын тосны геологич хүн. Тэрээр Америкын Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкын Геологийн Нийгэмлэгийн гишүүн.

Редакторуудад зориулсан санамж:

Петро Матадын тухай

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурвалт Бүтээгдхүүн Хуваах Гэрээнүүдийг дангаараа гүйцэтгэгч байгууллага болно. Гол хөрөнгө нь тус орны алс дорнодод байрлах 14,250 квадрат км талбай бүхий газрын тосны ХХ блокд байгуулсан Бүтээгдхүүн Хуваах Гэрээт талбай. Нөгөө хоёр 4 ба 5 -р блокууд нь Монгол улсын төв хэсэгт байрлах бөгөөд хамтдаа 73,498 квадрат км талбайтай.

Петро Матад Лимитед компани нь Айслофф Мэн ард 1483 Вурнэлгэй байгуулагдсан компани бөгөөд албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Байшин, Проспект Хилл, Дуглас, Айслофф Мэн, Ай Эм 1 –ИКю хаягт байрладаг болно.

Цаашдын мэдээллийг дараах хаягаар авч болно:

Петро Матад Лимитед
Дуглас Жэй. МкГэй- Гүйцэтгэх Захирал +976-11-331099

Вестхаус Секюритис Лимитед
Ричард Бэйти / Петре Нортон +44/0/ 20 7601 6100

Банкны талын зөвлөхүүд
Саймон Розсчайлд / Оливер Винтерс / Луйс Мэйсон +44/0/ 20 7367 8888